



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 32-35-89,
E-mail: info@mecss.gov.mn, http:www.mecss.gov.mn

2018. 09. 10 № 9/10593
танай _____-ны № 03/7128 -Т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлж байна.

/хавсралт 8 хуудас/

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ С. МӨНХӨӨЛЭЙ



09 10770

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хавсралт

№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Биелэлт
1	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах	2016-2023	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2017 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан "Сургалтын агуулгын талаар баримтлах бодлого, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага боловсруулах, дунд, ахлах ангийн сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээ, арга зүйн шинэчлэл хийх, ахлах ангийн сургалтын төлөвлөгөө боловсруулах, суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшил болон багшийн ажлыг үнэлэх үнэлгээний журам шинэчлэх ажлыг гүйцэтгэх" ажлын хэсгээс боловсруулсан "Сургалтын агуулгын талаар баримтлах бодлого"-ын төсөл боловсруулаад байна. Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийн суралцагчид "Нийгмийн ухаан" сонгон суралцах хичээлийн 6 дугаар бүлэгт "Шударга ёс ба авлига" бүлэг сэдвийн хүрээнд шударга ёсны үүднээс шинжилгээ хийн авлигд холбогдох асуудлыг тодорхойлох, авлигын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлд үзүүлэх сөрөг үр нөлөөг тодорхойлох, тайлбарлах, авлигаас зайлсхийх иргэний санаачлагын хувилбар дэвшүүлэн хамгаалах агуулга бүхий төсөл боловсруулсан.
2	Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах	2016-2023	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг их, дээд сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт тусгах талаар судалгаа хийгдэж байна. 2017-2018 оны хичээлийн жилд нийт их дээд сургуулиуд оюутан, суралцагчдын дунд хар тамхи мансууруулах бодис, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын хууль тогтоомж зөрчихгүй байх талаар Цагдаагийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, лекц, өдөрлөгийн зохион байгуулж, гарын авлага, брошур хэвлэж тусгах ажил өргөн хүрээтэй хийгдсэн. 2018-2019 оны хичээлийн жилийн бэлтгэл, өвөлжилтийн бэлтгэл, гэнэтийн аюул, Үер, гал түймэр, архидан согтуурах явдалтай тэмцэх зэрэг болон хичээлийн жилийн зорилгоо тодорхойлон хэлэлцэх ажлын хүрээнд Их, дээд сургуулиудын захирлуудын дунд "Боловсролын чанар-удирдлагын манлайлагч" сургалт хэлэлцүүлэгийг зохион байгуулж 85 их дээд сургуулийн удирдлагууд оролцлоо.

3	<p>Оюутан, суратч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах</p>	2016-2023	<p>Улсын хэмжээнд нийт ерөнхий боловсролын дунд ахлах ангийн суралгчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын хууль тогтоомж зөрчихгүй байх талаар холбогдох байгууллагатай хамтран, лекц, өдөрлөгийг зохион байгуулсан байна. Сургалтын төлбөр- Оюутны хөгжил" сэдэвт их, дээд сургуулиудын захирал, оюутны байгууллагуудын нэгдсэн анхдагч хуралдаан, хэлэлцүүлэг 2018 оны 09 дүгээр сарын 06-ны 09 цагаас болж Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, Монгол улсын ерөнхийлөгчийн оюутны хөгжлийн асуудал харуцсан орон тооны зөвлөх Н.Лхагвадорж нар зохион байгуулагчаар ажиглаж, БСШУСЯ-ны дээд боловсролын бодлогын газар, их дээд сургуулиудын захирал, оюутны холбоод, зөвлөлүүдийн тэргүүнүүд, оюутны байгууллагын төлөөлөгчид оролцно. Монгол улсын дээд боловсролын салбар дахь их дээд сургуулиудын сургалтын төлбөртэй холбоотой сургуулийн удирдлага, оюутнууд хоорондын үл ойлголцлыг тодорхойлж, харилцан зөвшилцөж, хамтран ажиглаж, цаашид Монголын оюутны хөгжлийг сайржуулах арга замыг тодорхойлон хэлэлцэн зөвшилцлөө.</p>
4	<p>Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, харилцлагыг дээшлүүлэх</p>	2016-2023	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон салбарын харьяа байгууллагын удирдах албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн иргэдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай Авлигатай тэмцэх газраас ирсэн албан тоотыг сайдын болон төрийн нарийн бичгийн даргын тушаалын үндэслэл хэсэгт оруулж, нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилох шийдвэр гаргаж байна. АТГ-ын ХАСХОМ-ын тайланд 2017 оны байдлаар урьд жилд томилогдсон мэдүүлэг гаргалгын тоо 361, ажлаас чөлөөлөгдсөн хасагдсан 7, тухайн жилд хасагдсан мэдүүлэг гаргалгын тоо 89, мэдүүлэг гаргавал зохих мэдүүлэг гаргалгийн тоо 272, үүнээс хугацаандаа мэдүүлсэн 336, Тухайн жилд мэдүүлэг гаргагч, мэдүүлгийг хүлээн авсан хэлбэрээр гараас гарт 2, баталгаат шуудангаар 1, Их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн тоо 2 байна.</p>
5	<p>Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мөрит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх;</p>	2016-2023	<p>Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг өндөрсгөж, шалгуурыг Ажлын байрны тодорхойлолтод тусгаснаар албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мөрит зарчмыг баримтлан томилгоо хийдгэнэ гэж үзэж байна. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/230 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг БСШУСЯ-ны ажлын байрны шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар ажиглаж байна.</p>

6	<p>Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;</p>	2016-2023	<p>Нийтийн албанд томилогдсон этгээдтэй хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулж, хагас жил болон жилийн эцсээр 2 удаа үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэдэг. Мөн "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн "Албан даалгаврын хэрэгжилтийг хангах тухай" А/288 дугаар тушаалыг батлан, салбарын хэмжээнд мөрдүүлж ажиллаж байна. Уг тушаалаар "Албан даалгавар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гарган ажиллах, ажлын хариуцлага, дэг журам болон албан хаагчдын манлайлал үр чадварыг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээний төлөвлөлт, хэрэгжилт, тайлангалийг сайжруулахыг шат шатны байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасан болно. Мөн Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгавар, 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУСЯ-ны ТНБД-ын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн "Яамны дотоод үйл ажиллагааг сайжруулах тухай" А/226 дугаар тушаалыг баталсан. Уг тушаалд яамны газар хэлтсийн дарга, нийт албан хаагч нарын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 5 зүйл, 25 хэсэг бүхий үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тусгаж, ажил эрчимжүүлэх зорилгоор чиглэл бүрт ажлын хэсэг томилон ажиллуулж байна.</p>
7	<p>Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх;</p>	2016-2023	<p>Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах, батлуулах ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.</p>

8	<p>Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх</p>	2016-2023	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм", "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг тус тус баталлаа. Энэ удаагийн ёс зүйн дүрэм нь багш, ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, даган биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зарчим, хэм хэмжээ зөрчилдөхөөс урьдчилан сэргийлэх, багш мэргэжлийн нэр хүндийг хамгаалахад чиглэсэн. Түүнчлэн багш, ажилтны хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах, хариуцлага хүлээлгэх асуудлыг тодорхой тусгах, ажил олгогч ёс зүйн дүрмийг мөрдүүлж хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах, энэхүү дүрмийг зөрчиж, зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр тус тус тусгалаа. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус "Ёс зүйн зөвлөл" аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллах бол сургууль, цэцэрлэгийн түвшинд зөрчил гаргасан эсэхийг хянан шалгах 3 буюу түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажиллуулахаар журамлалаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар баталсан "Ёс зүйн дүрэм болон Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хургуулж, улмаар захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3909 дугаарт бүртгэв. Уг ажлын хэсэгт авлигатай тэмцэх ажлын хүрээнд нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгохтой холбогдуулан хяналтын тогтолцоог бүрдүүлэх үүднээс БСШУСЯ-ны орох гарах хэсэгт Санал хүсэлт авах хайрцаг байршуулахаар ажиллаж байна.</p>
---	---	-----------	---

<p>Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>2016-2023</p>	<p>1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Хөтөлбөр, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай" А/052 дугаар тушаалыг боловсруулж батлууллаа. Тус тушаалаар яамны нийт харьяа байгууллагын удирдлагуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг өгсөн. Энэхүү тушаалыг нийт 94 байгууллагад яамны дотоод сүлжээгээр /цахим/ хүргүүлсэн. Тушаалын хэрэгжилтийг жилд 2 удаа буюу 7, 12 дугаар сард тогтмол яаманд ирүүлж байх чиглэлийг Төрийн нарийн бичгийн даргын гарын үсэг бүхий албан бичгээр мөн байгууллагуудад хүргүүлээд байна. 2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрт нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ аливаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ талаар тайлбар, мэдэгдлийг удирдлагад гаргаж өгч ажиллах талаар яамны нийт албан хаагчдад мэдээллийн цагаар болон байгууллагын дотоод сүлжээгээр тайлбар, холбогдох шийдвэрийг хүргүүлж мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн холбогдох дүрэм журмын дагуу 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлийн "Ёс зүйн хороо байгуулах тухай" СЗ/5 дугаар тогтоолоор Ёс зүйн хороо шинэчлэн байгуулагдсан.</p>
<p>Шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;</p>	<p>2016-2023</p>	<p>2018 оны Байлдаар шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр хууль бус болсон тохиолдол одоогоор гараагүй байна.</p>
<p>Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах;</p>	<p>2016-2023</p>	<p>Албан хэрэг хөтлөлтийн Эйбл системийг 2018 онд яамны үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн, ажиллаж байна. Ингэснээр ажилтнууд хоорондоо дотоод чатаар харилцах, нийт ажилтнууд болон тусгайлан хүмүүсээс санал асуулга авах, тодорхой сэдвээр хэлэлцүүлэг явуулах, дундын болон хувийн файлын сан үүсгэх, зар мэдээ илгээх, шуурхай зарыг байгууллагын хэмжээнд, зөвхөн өөрийн хэлтэс хүрээнд гэх мэт бүлэглэн хүргэдэг боломжтойгоос гадна Эйбл системд холбогдсон бусад байгууллагын хэрэглэгчидтэй мөн чатаар харилцах, мэдээлэл солилцох боломжтой юм.</p>
<p>Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх.</p>	<p>2016-2023</p>	<p>2018 онд нийт албан хаагчидад "Төрийн албан хаагчдын үнэт зүйлс ба ёс зүй" сэдвээр Удирдлагын академис сургалт авсан. Нийт албан хаагчдад Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилт сэдвээр сургалт зохион байгуулсан, АТГ-аас зохион байгуулсан "Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт"-д яамны албан хаагчид хуваарийн дагуу идэвхитэй оролцсон. Мөн гадаад, дотоодын төслийн санхүүжилттэй сургалтад хариуцсан ажил, мэргэжлийн дагуу 1-14 хоногийн хугацаатайгаар албан хаагчдыг давтан сургаж байна.</p>

<p>Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;</p>		<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас иргэд, олон нийтийн эрх ашигт нийцүүлэн дараах арга хэмжээг 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчдийн баримт бичгийн тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний цахим ЛТЦ/ машинаас бүрэн олгодог болгох; 2. Боловсролын салбарын мэдээллийн системээр дамжуулан ерөнхий боловсролын сургуулийн суратчдын эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан модулийг боловсруулна. Ингэснээр эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ ирд, сурлагын дүн гэх мэт өөрийн хүүхэдтэй холбоотой мэдээллийг гар утсаар болон интернэт ашиглан авдаг болгох; 3. Боловсролын салбарын мэдээллийн системийг сургуулийн өмнөх боловсролын салбарт нэвтрүүлж суралцагчийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн, элсэлт, төгсөлтийн мэдээллийг бүртгэлжүүлэх системийг нэвтрүүлж эхлэх; 4. Яамны архивт хадгалагдаж буй цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, байгууллага, иргэд, олон нийтэд архивын лавлагааг түргэн шуурхай гарган өгч төрийн үйлчилгээний түргэн шуурхай байдлыг ханган ажиллаж байна.
<p>Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх;</p>	<p>2016-2023</p>	<p>Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл дээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.БСШУССайдын 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/258 дугаар тушаал/</p>
<p>эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох;</p>	<p>2016-2023</p>	<p>БСШУСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу БСШУСЯ-ны архлэх ажлын хүрээнд нь үйл ажиллагаа явуулж байгаа агентлаг, харьяа бусад байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулсан. Боловсролын салбарын эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлээр нэгж байгууллагад сургалт зохион байгуулж байна.</p>
<p>Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах;</p>	<p>2016-2023</p>	<p>Төрийн үйлчилгээг шударга, ил тод нээлттэй болгох зорилгоор "Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа" -г боловсруулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг тогтмол судалгаанд хамруулж, судалгааны үр дүнд хяналт шинжилгээ хийж байх талаар 2019 оны яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаад байна.</p>

17	<p>өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх.</p>	2016-2023	<p>Иргэдийг өөрсдийн гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтгээ хяналт тавих боломжтой болгох зорилгоор Яамны цахим хуудсанд болон мэдээллийн самбарт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг байршуулж байна. /1 сар тутам/ Нийт хүсэлт, өргөдөл, гомдлын дийлэнх хувийг эзэлдэг, зарим их, дээд сургууль, коллеж төгссөн дипломын болон ЕБС төгссөн гэрчилгээний лавлагаа, гадаадаас монголд сурч, ажиллах багш, оюутнуудад Монгол Улсад нэвтрэх болон оршин суух зөвшөөрөл хүсэх зэрэг богино хугацаанд буюу яаралтай харуу авахыг шаарддаг бичгийг харууцсан мэрэжлгтнүүдтэй зөвшилцөн, 7 хоногт нь багтаан шуурхай гаргах зохицуулалтыг хийж, хүсэлт гаргасан иргэн байгууллагад тодорхойлолтыг гарсан даруйд нь утсаар мэдэгдэж, шуурхай үйлчилгээ үзүүлдэг. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд цахим тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай үзүүлэлтүүдийг шалгуур болгон, судалгаа явуулсны үндсэн дээр Эйбл програмыг сонгож, 2018 онд яамны үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн, ажиллаж байна. Ингэснээр цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж, яамны албан хэрэг хөтлөх ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, заавар, дүрэм, журам, стандартын дагуу явагдаж, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтын систем сайжирсан.</p> <p>Цаашид Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор баталсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэх ажлыг шат дараалалтай зохион байгуулан ажиллана.</p>
18	<p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.</p>	2016-2023	<p>Зарим байгууллагууд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт хийн, сургууль орчинд "Эцэг эхийн эргүүл", "Багш-сурагч-эцэг эх", "Есзүйн зөрчилгүй хамт олон", "Хүүхдийн үгийг сонсох өдөр" зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.</p>